



МҮХАҮТ

МЭДЭЭЛЛИЙН ТОВХИМОЛ



2022.06.02

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ

Дугаар / 22.05

МОНГОЛ УЛСЫН 2021 ОНЫ ТОП 100 ААН ТОДОРЛОО

Монгол Улсын Засгийн газар, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн танхим хамтран нийгэм, эдийн засгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулж буй “ТОП-100 аж ахуйн нэгж”-ийг эрэмбэлж, өргөмжлөх үйл ажиллагааг 21 дэх жилдээ (2022.05.23) зохион байгууллаа.



1	Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ	26	Эрдэнэс Монгол ХХК	51	Номин Бизнес Клуб ХХК	76	Улаанбаатар Менежмент ХХК
2	Оюутолгой ХХК	27	М Си Эс Кокакола ХХК	52	Юнивист ХХК	77	Таванбогд Интернейшнл ХХК
3	Эрдэнэс Тавантолгой ХК	28	Мэдээлэл Холбооны Сүлжээ ХХК	53	Жи Си Ар Монголиа ХХК	78	Монос-Улаанбаатар ХХК
4	ХААН Банк	29	Барло Ворлд Монголиа ХХК	54	МОЭНКО ХХК	79	Волтам ХХК
5	Голомт Банк	30	Содмонгол Групп ХХК	55	Тэс Петролиум ХХК	80	Тотал Дистрибушн ХХК
6	Монгол Зөөвөлтийн ХНН УБТЗ ХХК	31	Скай Хайпермаркет ХХК	56	Шунхлай Трейдинг ХХК	81	Спирт Бал Бурам ХХК
7	Худалдаа Хөгжлийн Банк	32	Хишиг Арвин Индустриал ХХК	57	Алтан Жолоо Групп ХХК	82	Тийс Монгол ХХК
8	Төрийн Банк	33	Тэс Фүүдс ХХК	58	МСМ Групп ХХК	83	Монголын Цахилгаан Холбоо ТӨХК
9	НИК ХХК	34	Багануур ХК	59	Ачит-Илт ХХК	84	Саусоби Санде ХХК
10	Энержиресурс ХХК	35	Си Өү Эй Эл ХХК	60	Монполимет ХХК	85	Юнисервис Солонхи ХХК
11	Номинтав Трейд ХХК	36	Калиптон Банк	61	Таван Богд Фүүдс ХХК	86	Сүү ХК
12	Монголын Алт МАК ХХК	37	Жур-Үр ХХК	62	Алтайн Хүдэр ХХК	87	М Си Эс Интернейшнл ХХК
13	Болдтөмөр Ерөө Гол ХХК	38	Дулааны Гуравдугаар Цахилгаан Станц ТӨХК	63	Уорли Инженеринг ХХК	88	Эко Констракшн ХХК
14	АЛУ ХК	39	Санрал Экспресс Си Ви Эс ХК	64	Магнай Трейд ХХК	89	Баалаг Энержи Ресурс ХХК
15	Монголросцветмет ТӨҮГ	40	Радлаф Монгол ХХК	65	М Си Эс Проперти ХХК	90	СББ Трейд ХХК
16	Мобиком Корпораци ХХК	41	Шинь Шинь ХХК	66	Алтангадас Трейд ХХК	91	Баян Айраг Эксплорэйшн ХХК
17	Петролина Дачин Тамсаг ХХК	42	Лекс-Ойл ХХК	67	Бороо Гоулд ХХК	92	Номин Хайпермаркет ХХК
18	Юнител ХХК	43	Салпорт Сервисес Монголиа ХХК	68	Скайтел ХХК	93	Эко Глобал Логистикс ХХК
19	Дулааны Дөрөвдүгээр Цахилгаан Станц ТӨХК	44	МИАТ ТӨХК	69	Жимбайн ХХК	94	Шивээ Овоо ТӨХК
20	Говь ХК	45	Ти Ти Жи Ви Си Өү ХХК	70	Цемент Шохой ТӨХК	95	Алтан Тариа ХХК
21	Хас Банк	46	Номин Трейдинг ХХК	71	МАК Цемент ХХК	96	Интернейшнл Медикал Сентер ХХК
22	Дарканы Төмөрлөгийн Үйлдвэр ТӨХК	47	Алу Трейдинг ХХК	72	Монгол Шуудан ХК	97	Трансервис Монголиа ХХК
23	Бүрдэл Майнинг ХХК	48	Талх Чихэр ХК	73	Миний Дэлгүүр ХХК	98	Иижон ХХК
24	Шунхлай ХХК	49	Цайрт Минерал ХХК	74	Тавантолгой ХК	99	Таван Богд Фүүдс Пийца ХХК
25	Бодь Интернэшнл ХХК	50	Шангрила-Улаанбаатар Хотел ХХК	75	Петростар ХХК	100	Азифарма ХХК

2021 оны ТОП 100 ААН-ийн борлуулалтын орлогын хэмжээ өмнөх оноос 2.8 их наядаар өсч, 35.4 их наяд хүрсэн нь ДНБ-ий 82 хувьтай дүйцэж, ажиллагсдын тоо нь 8.3 мянгаар нэмэгдэж 99 мянгад хүрсэн нь нийт ажлын байрны 8.8 хувьтай тэнцэж байна. Эдийн засаг, бизнесээ сэргээхэд амаргүй жил байсан хэдий ч ТОП 100 ААН-ийн нийт төлсөн татварын хэмжээ өмнөх жилээс 26 хувиар өсч, 5.3 их наяд төгрөгт хүрлээ.



“КОВИДЫН ДАРААХ БИЗНЕСИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ МЕНЕЖМЕНТИЙН ХӨТӨЛБӨР” ОЛОН УЛСЫН СУРГАЛТ



24 ДЭХ УДААГИЙН SME-2022” ОЛОН УЛСЫН ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДАА БОЛЛОО



ЧӨЛӨӨТ БҮСИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ТАЛААР ХЭЛЭЛЦЛЭЭ



БИЗНЕСИЙГ ДЭМЖИХЭД ТӨРИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ДАРАМТЫГ БАГАСГАЖ, ҮР НӨЛӨӨГ ДЭЭШЛҮҮЛЭХЭЭР ЗӨВЛӨЛДӨВ



БИЗНЕСИЙН ЁС ЗҮЙ, ШУДАРГА БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ ТӨСЛИЙГ ҮРГЭЛЖЛҮҮЛЭН ХЭРЭГЖҮҮЛНЭ



ДЭЛХИЙН БАНК, АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКНЫ БИЗНЕСИЙН БОЛОМЖИЙН ТАЛААР БИЗНЕС ЭРХЛЭГЧДЭД ТАНИЛЦУУЛЛАА



МОНГОЛ-ХЯТАДЫН БАРИЛГЫН САЛБАРЫНХАН ЦАХИМААР УУЛЗАВ



МҮХАҮТ-ЫН ОНЫ ШИЛДЭГ ЭНТРЕПЕНЕР ААН-ҮҮДТЭЙ ТАНИЛЦАХ АЯЛА ЭХЭЛЛЭЭ



МЭДЭЭЛЛИЙН ТОВХИМОЛ

ЖДҮ, үйлчилгээ эрхлэгчдэд “Ковидын дараах бизнесийг эрчимжүүлэх менежментийн хөтөлбөр” олон улсын сургалтыг зохион байгуулж эхэллээ



Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар, МҮХАҮТ-ын дарга Т.Дүүрэн нар (2022.05.30)Хамтын ажиллагааны санамж бичиг байгууллаа. Санамж бичиг байгуулснаар МҮХАҮТ-ын зүгээс хэрэгжүүлж буй “1000 CEO, 1000 хүчирхэг компани” хөтөлбөрийн хүрээнд жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд зориулсан “Ковидын дараах бизнесийг эрчимжүүлэх менежментийн хөтөлбөр”

олон улсын сургалтад нийслэлийн зүгээс хамтран ажиллах боломж бүрдэж байна.


Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй иргэдэд зориулан сургалт зохион байгуулж, эдийн засаг, санхүүгийн зохих мэдлэг олгон, чадавхжуулснаар тэдэнд үйл ажиллагаагаа тууштай явуулах боломж нээгдэх чухал ач холбогдолтой юм.

24 дэх удаагийн “Жижиг дунд үйлдвэрийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, технологи–2022” олон улсын үзэсгэлэн худалдаа боллоо

Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим, Жижиг, дунд үйлдвэрийн газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар хамтран “Жижиг Дунд Үйлдвэрийн Бүтээгдэхүүн, Үйлчилгээ, Технологи–2022” Олон улсын үзэсгэлэн худалдааг 24 дэх жилдээ 2022 оны 5 дугаар сарын 19–22-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулж дууслаа. Нийслэл орон нутгийн нийт 90 гаруй жижиг дунд ААН, хувиараа бизнес эрхлэгчид оролцож, үүний дотор хөдөө орон нутгаас Дархан, Орхон, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв, Хөвсгөл аймгууд

оролцож, бараа бүтээгдэхүүнээ танилцуулав.

Үзэсгэлэнгийн шалгаруулалтад нийт 50 байгууллагын бүтээгдэхүүн, үйлчилгээ нэр дэвшин өрсөлдсөнөөс шилдгээр шалгарсан 13 байгууллага, тэдний бүтээгдэхүүн, үйлчилгээ шалгарлаа. Монгол Улсад үйлдвэрлэсэн ноолууран бүтээгдэхүүнийг дотоодын болон гадаадын зах зээлд нийлүүлж байгааг өндрөөр үнэлэн “ГУРВАН СОР” ХХК-д тус үзэсгэлэнгийн ДЭЭД ШАГНАЛ “ГРАН-ПРИ” ЦОМ, ХҮНДЭТ ӨРГӨМЖЛӨЛ олгожээ.



Эдийн засаг, хөгжлийн яам, МҮХАҮТ хамтран чөлөөт бүсийн одоогийн хүчин төгөлдөр хууль, эрх зүйн орчныг сайжруулах, цаашдын хөгжлийн чиглэлийг тодорхойлоход оролцогч талуудын саналыг тусгах зорилгоор “Чөлөөт бүсийн хөгжлийн бодлого” хэлэлцүүлгийг /2022 оны 05 дугаар сарын 13-нд/ зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт холбогдох төрийн байгууллагууд,

Чөлөөт бүсийн хөгжлийн бодлогын талаар хэлэлцлээ

чөлөөт бүсийн захирагчийн ажлын албадын төлөөлөл болон хөрөнгө оруулагчид, тээвэр логистикийн салбарын бизнес эрхлэгчид оролцов. Чөлөөт бүсүүдийг хөгжүүлэхэд нэн түрүүнд хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлагатай байгаатай хэлэлцүүлэгт оролцогчид санал нэгдэж байлаа. Мөн чөлөөт бүсийн хөгжлийн загварыг зөв тодорхойлох, хөрш орнууд, бүс нутгуудтай харилцан ойлголцох, ерөнхий төлөвлөгөөгөө уялдуулах, төр-хувийн хэвшлийн хамтарсан менежментийг нэвтрүүлэх зэрэг саналуудыг илэрхийлсэн юм.



МЭДЭЭЛЛИЙН ТОВХИМОЛ

Бизнесийг дэмжихэд төрийн хяналт шалгалтын дарамтыг багасгаж, үр нөлөөг дээшлүүлэхээр зөвлөлдөв



МҮХАҮТ, Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар, Олон улсын санхүүгийн корпорацитай хамтран “Бизнесийг дэмжихэд төрийн хяналт шалгалтын дарамтыг багасгаж, үр нөлөөг дээшлүүлэх” сэдэвт уулзалтыг (2022.05.25) зохион байгууллаа. Оролцогчдын зүгээс Мэргэжлийн хяналтын байцаагч нарын ур чадварыг нэмэгдүүлж, мэргэшүүлэх, сэлгэн ажиллуулах, аж ахуйн нэгжүүд байгууллагын дотоод хяналтаа сайжруулах, экспортод шаардлагатай гэрчилгээг МХЕГ-аас авах үйл явцыг цахимжуулж, хугацааг богиносгох,

лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, дүрэм журам стандартуудыг олон улсын стандартуудтай уялдуулан шинэчлэх, төрийн байгууллага хоорондын нэгдсэн уялдаа холбоог сайжруулах, хэрэглэгчдэд хандсан чанар, аюулгүй байдалтай холбоотой мэдээллээр олон нийтийг хангах зэрэг нийтлэг асуудлуудыг хувийн хэвшлийнхний зүгээс тавьж байлаа. Түүнчлэн стандарт, дүрэм журмуудыг өөрчилж, шинэчлэхэд мэргэжлийн холбоодын зүгээс хамтран ажиллаж боломжтойгоо илэрхийлэв.

Бизнесийн ёс зүй, шударга байдлыг бэхжүүлэх төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ



“Бизнесийн ёс зүй, шударга байдлыг бэхжүүлэх” төслийн нэг жилийн үйл ажиллагааны тайлангийн уулзалт /2022 оны 05 дугаар сарын 13-нд/ боллоо. Төслийг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим, “Транспэрэнси Интернэшнл Монгол” ТББ болон “Рио Тинто Монгол” ХХК нь хамтран хэрэгжүүлж байгаа бөгөөд бизнесийн орчин дахь авлигын тархалтыг зогсоох, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд

хэрэгжих төсөл, хөтөлбөрүүдэд дэмжлэг үзүүлэх замаар, урт хугацаанд бизнесийн ёс зүй, шударга байдлыг бэхжүүлэхээр ажиллав. Уулзалтын төгсгөлд “Бизнесийн ёс зүй, шударга байдлыг бэхжүүлэх” төслийг хэрэгжүүлэгч талууд Бизнесийн ёс зүйн төвийн нэг жилийн үйл ажиллагааг дүгнэн хэлэлцэж, ирэх жилийн үйл ажиллагааны төлөвлөлтийг танилцуулан төслийн тунхаглалт гарын үсэг зурлаа.

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ

ДЭЛХИЙН БАНК, АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКНЫ БИЗНЕСИЙН БОЛОМЖ

МЭДЭЭЛЭЛ ОЛГОХ СУРГАЛТ, УУЛЗАЛТ

- ДБ, АХБ-ны техникийн туслалцаа, төсөл хөтөлбөрийн танилцуулга
- Төсөл хөтөлбөрт хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжүүдийн оролцоо, боломж
- Тендер шалгаруулалт, гэрээ байгуулах, “Байгаль орчин, нийгмийн талаарх стандарт”

Дэлхийн банк, Азийн хөгжлийн банкны бизнесийн боломжийн талаар бизнес эрхлэгчдэд танилцууллаа

Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим, Азийн Хөгжлийн Банк, Дэлхийн Банктай хамтран “Дэлхийн банк, Азийн хөгжлийн банкны

авах ажиллагааны талаар шаардлагатай чадавх, худалдан авах ажиллагаанд хэрхэн оролцох, ямар дүрэм журмаар явагдах, ажил гүйцэтгэх явцад



бизнесийн боломж” мэдээлэл олгох сургалт, уулзалтыг (2022.05.20) зохион байгууллаа. Энэ үеэр Дэлхийн банк, Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлж буй төслүүдийн мэдээлэл, худалдан



байгаль орчин, нийгмийн ямар дүрэм журмуудыг баримтлахтай холбоотой илтгэлүүдийг танилцуулж, нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлээ.

МЭДЭЭЛЛИЙН ТОВХИМОЛ

Монгол-Хятадын барилгын салбарынхан цахимаар уулзав



МҮХАҮТ, Бээжин хотын худалдааг дэмжих хороо, Бээжин хотын барилгын холбоо хамтран БНХАУ-ын барилгын материал үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдийг Монголын барилгын салбарынханд танилцуулах цахим уулзалтыг (2022.05.18) зохион байгууллаа. БНХАУ-ын барилгын салбарын 7 компани, Монголын талаас 25 компанийн төлөөлөл уулзалтад оролцов. Хятадын компаниуд өөрийн үйл ажиллагааг видео, илтгэл хэлбэрээр танилцуулсны дараа аж ахуйн нэгжүүд

сонирхож буй компанитайгаа B2B уулзалт хийлээ.



МҮХАҮТ-ын оны шилдэг Энтрепенер ААН-үүдтэй танилцах аялал эхэллээ



МҮХАҮТ-ын “Оны Шилдэг аж ахуйн нэгж”-ээр шалгарсан компаниудын ажлын амжилт, туршлагыг бусад гишүүд, бизнес эрхлэгчдэд таниулан сурталчлах, цаашид гишүүд хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагааг

өргөжүүлэх зорилгоор “Энтрепенерийн аян”-г 2005 оноос эхлэн жил бүр уламжлал болгон зохион байгуулж ирсэн билээ. 2021 оны шилдэг аж ахуйн нэгжүүдтэй танилцах аялал ХААН банк, Хаан цамхагтай танилцсанаар эхэлсэн

бол үргэлжлүүлэн Эрдэнэс Тавантолгой ХК, Өмнөговь аймгийн Цогтцэций суман дахь Цанхи хотхон, Зүүн, баруун цанхийн үйл ажиллагаа, Зүүнбаян төмөр зам, Тавантолгой төмөр замын бүтээн байгуулалтын явц болон нүүрс

баяжуулах үйлдвэрийн бүтээн байгуулалттай танилцах аялаар үргэлжиллээ.

